



Монгол Улс: Институцийн  
өөрчлөлт хийх замаар эрдэс  
баялагийн менежментийг  
сайжруулах санаачилга (MERIT)

# Сургагч багш бэлтгэх курс

2018 оны 9 дүгээр сарын 4-7-ны өдрүүд  
Тэрэлж, Монгол улс

Жинэтт Жонстон, Техникийн зөвлөх

# Хоёрхон дүрэм мөрдөнө!

- Асуулт гарвал тэр даруй нь асууна.
- Гар утасныхаа дууг хаан, чичиргээн дээр нь тохируулна.

# Сургалтын загвар: Хичээлийн зорилтууд

Энэ хэсгийн төгсгөлд оролцогчид дараах зүйлсийг гүйцэтгэх чадвартай болно.

- Насанд хүрэгчид яагаад хүүхдүүдээс ялгаатай суралцдаг шалтгааныг тайлбарлах
- Колбийн туршилтаар суралцахуйн мөчлөгийг тайлбарлах
- ADDIE загварын үе шатуудыг дүрслэх


# Насанд хүрсэн суралцагчдын ОНЦЛОГ

- Цагийн өөр мэдрэмжтэй байдаг.
- Өмнө нь суралцсан мэдлэг, туршлагын “тушаатай” байдаг.
- Практик шаардлагад тулгуурладаг.
- Илүү эрсдэлтэй.
- Өөрсдөө сонголт хийдэг.

# Колбийн туршилтаар суралцахуйн МӨЧЛӨГ



# ADDIE загвар



## Сургалтын хэрэгцээг үнэлэх: Хичээлийн зорилтууд

Энэ хэсгийн эцэст оролцогчид дараах зүйлсийг гүйцэтгэх чадвартай болох юм.

- Сургалтын хэрэгцээний шинжилгээг үр дүнтэй гүйцэтгэх
- Найдвартай хэрэгцээний судалгааны асуулгын асуулт боловсруулах

# Сургалтын хэрэгцээг үнэлэхийн ач холбогдол

Дараах зүйлсийг магадлах боломжийг олгодог учраас сургалтын хэрэгцээг үнэлэх нь чухал юм.

- Хэтэрхий бага эсвэл хэтэрхий их сургалт явуулахаас зайлсхийх
- Буруу сургалт явуулахаас зайлсхийх
- Бодит хэрэгцээ шаардлагад төвлөрөх



# Яагаад?

Сургалтын хэрэгцээний шинжилгээг дараах зорилгын үүднээс гүйцэтгэдэг. Үүнд:

- Суралцагчид чухам юу мэддэг, юу мэдэхгүй байгааг тодорхойлох
- Бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
- Хичээлийн зорилтуудыг тодорхойлоход чиглүүлэх
- Курсийн агуулгыг тодорхойлох
- Сургалт нь зөв шийдэл гэдгийг магадлах.

## Зөрүүтэй байдлын шинжилгээ

- Нөхцөл байдлыг илэрхийлэгч хүчин зүйлсийн жагсаалт
  - Ирээдүйн зорилгодоо хүрэхэд шаардлагатай хүчин зүйлсийг жагсаах
  - Дээрх хоёрын хооронд оршин байгаа, нөхөх хэрэгтэй аливаа зөрүүг тодруулах
- 
- Эх сурвалж: [www.businessdictionary.com/definition/gap-analysis.html](http://www.businessdictionary.com/definition/gap-analysis.html)

# Асуултын төрлүүд

- Нээлттэй асуулт
- Олон сонголтот асуулт
- Түвшинг үнэлэх асуулт

## Сайн судалгаа нь:

- Танилцуулга хэсэгтэй.
- Судалгаанд хэдий хэр хугацаа орохыг урьдаас мэдээлсэн.
- Тодорхой чиглэл бүхий ойлгомжтой асуултуудтай.
- Зорилтот бүлгийн унших чадварын түвшинг харгалзан үзсэн.
- Үргэлж, ихэвчлэн, огт үгүй, ховорхон зэрэг үгсийг хэрэглэхээс зайлсхийсэн.
- Нэг дор хоёр асуулт асуухаас зайлсхийсэн.
- Үндэс язгуур, шашин шүтлэг эсвэл жендэрээр ялгаварласан утгатай үгсийг ашиглаагүй.
- Хэт хувийн шинж чанартай асуултуудыг асуудаггүй.
- Үгүйсгэсэн үгээр илэрхийлсэн асуулт ашигладаггүй.
- Хариултыг санаатайгаар чиглүүлдэггүй.
- Нарийн мэргэжлийн болон техникийн үг хэллэг ашиглахаас зайлсхийдэг.
- 'Бусад', 'мэдэхгүй' болон 'хамааралгүй' зэрэг сонголтуудыг ашигладаг.
- Санал сэтгэгдлээ илэрхийлэх орон зай өгдөг.

# Хэмжигдэхүйц зорилт : Хичээлийн зорилтууд

Энэ хэсгийн төгсгөлд оролцогчид дараах зүйлсийг гүйцэтгэх чадвартай болох юм.

- Сургалтын зорилт хэмжигдэхүйц байхын ач холбогдлыг тайлбарлах
- Суралцахуйн гурван зорилтот талбарыг жагсаан, тайлбарлах
- SMART сургалтын зорилт боловсруулах

## Үр дүнтэй сургалтын зорилт

Сайн боловсруулсан сургалтын зорилтууд нь:

- Оролцогчдод хүлээлтийг тодруулж өгөх
- Курсийн агуулгыг сонгоход чиглэл болох
- Тухайн курсээр юунд хүрэхээр харж, хүлээж буйг хамтрагч талуудад мэдээлэх
- Сургалтанд бусдын дэмжлэг, баталгаа авахад туслах
- Сургалтыг үнэлэх суурь болж өгдөг байна.

## Суралцахуйн зорилтот талбар

- Мэдрэмж,  
хандлагын



- Танин мэдэхүй,  
сэтгэлгээний



- Дадал чадварын



# SMART зорилт

- **S** – specific буюу тодорхой
- **M** – measurable буюу хэмжигдэхүйц
- **A** – achievable буюу хүрч болохуйц
- **R** – relevant буюу хамааралтай
- **T** – time lined буюу цаг хугацаатай байх



## Сургалтын зорилт бичих

*Энэ семинарын эцэст оролцогчид .... (үйл хөдлөл заасан үг) чадвартай болох юм.*

Энэ семинарын төгсгөлд суралцагчид (сэдвийн) талаарх өөрсдийн (итгэл үнэмшил, хандлагыг) ... (үйл хөдлөл заасан үг) замаар харуулах юм.

# Сургалтын агуулга, бүтэц: Хичээлийн зорилтууд

Энэ хэсгийн төгсгөлд оролцогчид дараах зүйлсийг гүйцэтгэх чадвартай болно.

- Сургалтын агуулгыг логик уялдаа холбоотойгоор зохион байгуулах
- Сургалтын загварын конспект бичих

# Агуулгыг сонгох нь

Оюун бодлоо  
уралдуулах

Бүлэглэх

Хасах

Нягтлан үзэх



Конспект

# Хичээлийн агуулгын дараалал

- Ач холбогдлын дарааллаар
- Энгийнээс хүнд хэцүү рүү
- Ерөнхийгөөс тодорхой руу
- Мэддэгээс мэддэггүй рүү
- Он цагийн дарааллаар

# Заах арга, дуу дүрс бүхий сургалтын хэрэглэгдэхүүн: Хичээлийн зорилтууд

Энэ хэсгийн төгсгөлд оролцогчид дараах зүйлсийг гүйцэтгэх чадвартай болно.

- Хэд хэдэн заах аргын тухай ярилцаж, хооронд нь харьцуулах
- Үр өгөөжтэй дуу дүрс бүхий сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох

## • Заах арга

Заах арга гэдэг нь агуулгыг суралцагсдад дамжуулан хуваалцахад ашигладаг арга юм.


# Дуу дүрс бүхий сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн

- Дуу дүрс бүхий сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн нь
- таны илтгэл, танилцуулгад
- **ТУСАЛДАГ!**



## Самбарын цаас ашиглах зөвлөмж


- Тэмдэглэх зүйлсээ том самбарын цаасан дээр урьдчилан бичээрэй.
- Маркер тань гарч байгаа эсэхийг урьдчилан шалгана уу.
- Бараан өнгөтэй маркер ашиглаарай.
- Том үсгээр хэвлээрэй.
- Том бөгөөд гаргацтай бичээрэй.
- Нэг мөрөнд 5-аас илүүгүй үг ашиглах, нэг хуудсанд 5-аас ихгүй мөр бичих
- Хоёр самбарын цаас зэрэг ашиглаарай.
- Хуудас цаасны дээд талын  $2/3$  хэсэгт л юм бичээрэй.
- Сайн дураараа туслах хүн байгаа эсэхийг асуугаарай.
- Хамгийн чухал зөвлөмж бол “гараараа хүр, эргэн хар, тэгээд ярь”.





# Дүрс бүхий хэрэглэгдэхүүнийг үр дүнтэй ашиглах зөвлөмж

- Ямар нэг зураг дүрс аль нэг санааг тодотгож болохуйц хэсгүүдийг бичиж тэмдэглэнэ.
- Зураг дүрс хэрэглэгдэхүүний ноорог зургийг гаргана.
- Нүд эрээлжлүүлсэн замбараагүй зураг ашиглахаас зайлсхийгээрэй.
- 7 мөр текст (+/- 2) эсвэл нэг гол графикаас их зүйл оруулахгүйгээр агуулгыг хязгаарлаж байх.
- Нүдэнд эвтэйхэн харагдах, зарим санааг тодруулах, санаануудыг хооронд нь ялгахын тулд өнгө ашиглаарай.
- Тогтмол нэг янз байлгах.
- Үзүүлэнд тань алдаа гарсан эсэхийг нягтлан шалгах



Зогс

Эхлүүл

Яв

# Та ямар амьтанд дуртай вэ?

1. Нохой
2. Тэмээ
3. Ямаа
4. Гөрөөс

# Та ямар хөгжимд дуртай вэ?

1. Ардын
2. Орчин үеийн
3. Дуурь
4. Сонгодог


# Та ямар өнгөнд дуртай вэ?

1. Улаан
2. Цэнхэр
3. Шар
4. Ногоон

# Та хэдэн сард төрсөн бэ?

1. Нэгдүгээр сар, Хоёрдугаар сар, Гуравдугаар сар
2. Дөрөвдүгээр сар, Тавдугаар сар, Зургадугаар сар
3. Долдугаар сар, Наймдугаар сар, Есдүгээр сар
4. Аравдугаар сар, Арван нэгдүгээр сар, Арван хоёрдугаар сар

# ADDIE загвар



## Суралцагчдыг чиглүүлэх, тэдэнтэй холбогдох: Хичээлийн зорилтууд

Энэ хэсгийн төгсгөлд оролцогчид дараах зүйлсийг гүйцэтгэх чадвартай болно.

- Бие халаах 6 өөр дасгал ажлыг жагсааж, тайлбарлах
- Чиглүүлэх ур чадвараа үр дүнтэй ашиглах
- Чиглүүлэх явцад сандарсан байдлаа даван гарах




## Чиглүүлэх үйл хэрэг

Чиглүүлэх гэдгийг аливааг “хялбар болгох” буюу “тухайн үйл явцыг хөнгөвчлөх” хэмээн тодорхойлжээ. Чиглүүлэгч буюу сургагч багшийн гүйцэтгэдэг зүйл бол сургалтад хамрагдаж байгаа хүмүүс тодорхой сэтгэж, сайн оролцоотой байж, хүн болгоны бүрэн дэмжлэгийг авснаар бүлэг тавьсан зорилтдоо амжилттай хүрэхийг бататгах үүднээс бүлгийн арга хэмжээг төлөвлөж, чиглүүлж, удирдах явдал юм.

# Чимээгүй илгээлт

Мехрабиан



- Үг
- Дуу хоолойны өнгө
- Биеийн буюу аман бус илэрхийлэл

# Бусдад ойлголт төрүүлэх

- Үг
- Дуу хоолой
- Үйл хөдлөл
- Дохио зангаа
- Хурд
- Гадаад төрх

## Ур чадвар ба зөвлөмж

- Бичсэн зүйлсээ цээжлэх хэрэггүй.
- Үргэлж бүлэгтэйгээ эргэн тулгаж байх
- Нэгтгэн дүгнэж, түр зогсолт аваарай.
- Өөрийн биеэ авч явах байдлаа мэдээрэй.
- Гартаа ямар нэгэн зүйл бариарай.
- Хэлж буй үгээ хянаарай.
- Өөрийн биеийн хэлэмжийг ашиглаарай.
- Самбар болон хана руу харж ярихгүй байх.

Дараах эх сурвалжаас авч, өөрчлөн хэрэглэв: <http://ctb.ku.edu/e/table-of-contents/leadership/group-facilitation/facilitation-skills/main>

# Сандралаа даван гарах

- Бэлтгэ, бэлтгэ, бас дахин бэлтгэ
- Юм идэх эсвэл уухаас зайлсхийх.
- Илтгэлээс өмнө санаа бодлоо цэгцлэх
- Гүнзгий амьсгаа авах
- Сануулга ашиглах
- Сайн унтаж амрах

# Сургалтын үнэлгээ: Хичээлийн зорилтууд

Энэ хэсгийн төгсгөлд оролцогчид дараах зүйлсийг гүйцэтгэх чадвартай болох юм.

- Сургалтын зорилт болон сургалтын үнэлгээ хоорондын уялдаа холбоог тайлбарлах
- Киркпатрикийн үнэлгээний 4 түвшинг жагсаах
- Сурсан зүйлээ үр дүнтэйгээр ажил, амьдралд хэрэгжүүлэх талаар ярилцах

# Үнэлгээний ач холбогдол

- Энэ нь амжилтын түвшинг илтгэн харуулдаг.
- Сургалтын зорилтууддаа хүрсэн эсэхийг магадалдаг.
- Суралцагчдын хүчин чармайлтыг бататгадаг.
- Зардал гарган сургалт явуулсныг зөвтгөх үндэслэл болдог.
- Дараагийн сургалтыг боловсруулахад мэдээллээр хангадаг.
- Дахиад сургалт хэрэгтэй эсэхийг нотлоход тусалдаг.

# Юуг үнэлэх вэ?

- Зорилтууд
- Агуулга
- Сургагч багш
- Сургалтын материал
- Сургалтын загвар
- Дүү дүрс бүхий сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн
- Анги танхим





# Киркпатрикийн үнэлгээ

4 дүгээр түвшин:  
Үр дүнд хүрсэн байдал

- Сургалтын арга хэмжээ, түүний дараах бататгах үйл явцын үр дүнд зорилтот үр ашиг хэр зэрэг бий болсон байдал

3 дугаар түвшин:  
Зан төлөв

- Сургалтын явцад сурсан зүйлсээ ажлын байран дээрээ эргэн очсоны дараа хэр зэрэг ашиглаж байгаа байдал

2 дугаар түвшин:  
Мэдлэг эзэмшсэн  
байдал

- Сургалтын арга хэмжээнд оролцсон байдалд нь тулгуурлан оролцогчид зорилтот мэдлэг, үр чадвар болон хандлагыг хэр зэрэг эзэмшсэн байдал

1 дүгээр түвшин: Сэтгэл  
ханамж

- Сургалтын арга хэмжээнд хэр зэрэг нааштай хандаж байгаа байдал

# Сурсан зүйлээ ажил, амьдралд хэрэгжүүлэх

*Сурсан зүйлээ ажил, амьдралд хэрэгжүүлэх гэдэг нь “нэг эсвэл өөр нэг сургалтын орчинд олж эзэмшсэн зан төлөв, мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлэх суралцагчийн чадвар” юм.*

Эх сурвалж: [www.businessdictionary.com/definition/transfer-of-training.html](http://www.businessdictionary.com/definition/transfer-of-training.html)

# Сурсан зүйлээ ажил, амьдралд хэрэгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс

- Сургалтанд оролцогчийн онцлог
- Сургалтын хөтөлбөрийн загвар боловсруулах, түүнийгээ суралцагчдад хүргэх байдал
- Ажлын байрны орчин

# Илтгэл

- 6 багт хуваагдана.
- 30 минутын илтгэл
- Жендэрийн тэгш байдлын курсийн нэг дэд сэдвийн тухай байна.
- Илтгэл бүр
  - Сургалтын зорилтуудыг агуулсан удиртгал хэсэгтэй
  - Бие халаах дасгал (хамгийн ихдээ 5 минут)
  - Агуулга буюу үндсэн хэсэг
  - Дүгнэлт хэсгийг агуулна.
- Багуудад бүтэн үдээс хойш бэлтгэх хугацаа өгнө.
- Чиглүүлэгч/сургагч багш дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжтой.
- **Илтгэл тань маргааш өглөөний 9 цаг гэхэд бэлэн болсон байх ЁСТОЙ.**